

**“Нако түлш” ХК-ийн 2015 оны  
үйл ажиллагааны тайлан**

**1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:**

Компанийн нэр: ”Нако түлш” ХК  
Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн хотхон 13-р баг  
Утас: 70379006

**2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:**

Компанийн нэр: ”Нако түлш” ХК  
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2007.05.15  
Улсын бүртгэлийн дугаар: 000042648  
Регистрын дугаар: 4489969  
Үйл ажиллагааны чиглэл: Хагас коксон утаагүй түлшний үйлдвэрлэл  
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 12,615,721

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны мэдээлэл:**

“Нако түлш” ХК 2015 онд дараахи ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Үйлдвэрийн талбайд нийт 3911,2 тн нүүрс хүлээн авч 2628,9 тн нүүрс боловсруулан 1576,0 тн хагас кокс үйлдвэрлэж, 226 тн хагас кокс борлуулав.
- Зуухны дээд аманд гидро хаалт, зуух тэжээгч элеваторын угсралтын ажлыг гүйцээж, нүүрс ачаалах операторын байр шинээр хийснээр зууханд нүүрс ачаалах ажил, нүүрс ачаалах операторын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулсан.
- Хагас коксын хатаалгын хийн шугамын усан түгжээг дотор оруулан, хэмжээг томсгож битүүмжилснээр хатаалгын хийн шугамын аюулгүй байдал, найдвартай ажиллагаа нэмэгдсэн.
- Үйлдвэрийн барилгыг дулааны нөлөөлөлд орохоос сэргийлж шатдаг хийн янданг 4 метрээр сунгасан.
- Нүүрс хүлээн авах талбай, үйлдвэрийн барилгын дотор шал бетондож цутгав.
- Үйлдвэрийн барилгын хана суурийн хоорондох зайг бөглөж өрлөг өрөв.
- Зуухны дээд ажлын тавцан, тальны замыг сунгаснаар дээд ажлын тавцанд шаардлагатай ачаа, материалыг өргөж гаргах боломжтой болсон.
- Үйлдвэрт агааржуулалтын систем суурилуулсан.
- Үйлдвэрийн усны шугамуудад дулаалга, цахилгаан халаалт хийсэн.
- Зуухнуудын I, II сеператор, тосны шугам, циклонуудад уурын халаалтын хоолойнууд суурилуулж холбосон.
- I зуухны коксын конвейерт улны халаалт хийсэн.
  - Дээрхи халаалт, дулаалгын ажлуудыг хийснээр үйлдвэр өвөл хүйтний улиралд ажиллах боломж бүрдсэн.

## Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Тус компани нь 2015 оны 12-р сарын 31-ны өдрөөр дуусгавар болгон санхүү байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлээ Олон улсын стандарт болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гарган санхүү, татварын байгууллага болон холбогдох бусад газруудад тушаасан. Хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага “Голден пэйж аудит” ХХК-иар хянуулан баталгаажуулсан.

Компанийн 2014, 2015 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	2014 он	2015 он
Борлуулалт	110550,6	34584,5
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	185592,5	88058,4
Нийт ашиг	-75041,9	-53473,9
Үйл ажиллагааны бус орлого	4727,5	228,5
Үйл ажиллагааны зардал	283375,2	565067,5
Үйл ажиллагааны бус зардал	51512,3	398,5
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	-405201,9	-618711,4
Орлогын татварын зардал	38,2	114,6
Цэвэр ашиг,алдагдал	-405240,1	-618826,0

Үйл ажиллагааны борлуулалтын орлого 2015 онд “Тэгш хан” ХХК-д 23,81 тн нунтаг нүүрс, 12,38 тн хагас кокс, “Алтан хүнс” ХХК-д 10,32 тн нунтаг нүүрс, 10,92 тн хагас кокс, “Дархан Мөнхийн илч” ХХК-д 19,32 тн хагас кокс, “Орхон дэлгэр” ХХК-д 70,01 тн хагас кокс, бусад хэрэглэгчдэд 33,82 тн нунтаг нүүрс борлуулсан байна. Борлуулалт 2015 онд өмнөх онтой харьцуулахад 75 966,1 мянган төгрөгөөр буурсан байна. Мөн үйл ажиллагааны бусад зардалд “Шарын гол” ХК-иас 165 637,7 мянган төгрөг, ЕСБХБанкны зээлээс 102 461,5 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Цалин хөлсний зардалд 110 038,8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 21 944,9 мянган төгрөг, ашиглалтын зардалд 12 351,9 мянган төгрөг, түлш шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгслийн зардалд 9 441,3 мянган төгрөг, ХХОАТ 7 272,4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Компаний үндсэн хөрөнгөд 45 339,3 мянган төгрөгийн агааржуулалтын тоног төхөөрөмж нэмэгдсэн.

Компанийн 2014 он, 2015 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө өр төлбөрийн үзүүлэлтүүд	2014 он	2015 он
Эргэлтийн хөрөнгө	595958,3	814258,8
Эргэлтийн бус хөрөнгө	2909308,8	2854762,1
Нийт хөрөнгийн дүн	3505267,1	3669020,9
Богино хугацаат өр төлбөр	1045310,2	1725428,5
Урт хугацаат өр төлбөр	695224,7	797686,2
Эзэмшигчийн өмчийн дүн	1764732,2	1145906,1
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	3505267,1	3669020,8

**Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:**

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга	Дээд	Шарын гол ХК-ийн Гүйцэтгэх захирал
2	Грам Чапман	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Шарын гол ХК-ийн ТУЗ-н гишүүн
3	Б.Баярбат	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Нако түлш ХК-ийн ТУЗ-н гишүүн
4	Ж.Эрдэмбилэг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Си Би Эм ХХК-ийн гүйцэтгэх захирал
5	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК-ийн гүйцэтгэх захирал
6	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал
7	Д.Нарангоо	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Үнэмлэхүй эрх ХХК-ийн гүйцэтгэх захирал
8	Т.Тамир	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Амайзэ ХХК захирал, архитектор
9	Д.Түвшинтөгс	ТУЗ-ийн гишүүн	Дээд	МУИС Монгол хэл соёлын сургуулийн багш
10	Ж.Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	Дээд	

**Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан, цалин урамшууллын хэмжээ, үнэт цаас эзэмшдэг талаархи мэдээлэл:**

№	Овог нэр	Хараат бус гишүүн эсэх	Эзэмшиж байгаа хувьцааны тоо хувь	Цалин урамшууллын хэмжээ
1	Б.Батбаатар	Энгийн	эзэмшдэггүй	0₮
2	Грам Чапман	Энгийн	эзэмшдэггүй	0₮
3	Б.Баярбат	Энгийн	эзэмшдэггүй	0₮
4	Ж.Эрдэмбилэг	Энгийн	эзэмшдэггүй	0₮
5	Д.Даянбилгүүн	Энгийн	эзэмшдэггүй	0₮
6	Б.Лхагвадорж	Энгийн	эзэмшдэггүй	0₮
7	Д.Нарангоо	Хараат бус	эзэмшдэггүй	0₮
8	Т.Тамир	Хараат бус	эзэмшдэггүй	0₮
9	Д.Түвшинтөгс	Хараат бус	эзэмшдэггүй	0₮

## **Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаархи мэдээлэл:**

Компанийн хяналтын багц эзэмшигчийн мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Шарын гол ХК	Нүүрсний уурхай	92,93%

## **Ногдол ашгийн талаархи мэдээлэл:**

Компани нь 2015 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан.

## **Компанийн тухай хуулийн 87,89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл**

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. Компанийн хяналтын багц эзэмшигчдийн хувьд өөрчлөлт ороогүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Грам Чапман, Б.Баярбат, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, хараат бус гишүүдээр Д.Нарангоо, Т.Тамир, Д.Түвшинтөгс нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн “Нако Түлш” ХК 2015 оны 04 сарын 16-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2015 оны 04 сарын 16-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Т.Тамир, Д.Даянбилгүүн, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Т.Тамир гишүүнийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Грам Чэпмэн, Т.Тамир, Д.Түвшинтөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Грам Чэпмэн-г томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, Т.Тамир, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.

Компанийн ТУЗ 2015 онд нийт 6 удаа хуралдсан бөгөөд тогтоол шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

Компани нь 2014 оны 4 сарын 22-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Компани нь 2013 оны 4 сарын 22-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2012 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2012 оны санхүүгийн тайлан, хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн аудитын хорооны тайлан
4. 2013 оны ажлын төлөвлөгөөг батлах
5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2013 оны зардлын төсвийг батлах
7. Ногдол ашиг тараах эсэх
8. Бусад